ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ, ХАЙГУУЛЫН МЭДЭЭЛЭЛ



Уламжлалт газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн талбайнуудад хийгдсэн ажлын товч тойм:

Уламжлалт газрын тосны 4 талбай, Уламжлалт бус газрын тосны 7 талбайд /нүүрсний давхаргын метан хийн 6, шатдаг занарын 1/ нийт 11 талбайд эрлийн ажил гүйцэтгэж байна.

Эрлийн гэрээт талбайнуудад 2024 онд гүйцэтгэсэн ажлын нэгтгэл

1. Өрөмдлөг, дээжлэлт, хийн судалгаа

- Нийт 5 цооног өрөмдөж, 3364.3 тууш.м өрөмдсөн
- Цооногийн каротажийг 8 төрлийн аргачлалаар, 3363 тууш.м гүйцэтгэсэн
- 186 ширхэг нүүрсний хийн ялгарлын дээж
- 219 ширхэг нүүрсний чанарын дээж
- 112 дээжид хийн найрлагын шинжилгээ хийсэн

2. Газрын зураглал, геофизикийн судалгаа

- Геологийн зураглал: 1354.96 км²
- Эрлийн маршрут нийт: 827.56 т.км

- Соронзон хайгуул: 2708 т.км
- Хүндийн хүчний судалгаа: 960 ф.цэг
- Магнетотеллурик судалгаа: 60 ф.цэг

3. Судалгааны материалын боловсруулалт

- Өмнөх судалгааны материалуудыг нэгтгэж, дүн шинжилгээ хийсэн
- Нүүрс агуулагч хурдас, тэдгээрийн тархалтыг судалсан
- Агаар сансрын зургийг дахин боловсруулсан

4. Сорьцлолт ба шинжилгээ

- Геологийн сорьцлолт: 20 дээж
- Дээжлэлт, хийн найрлага тодорхойлох шинжилгээ гүйцэтгэсэн

5. Байгаль орчны болон соёлын үнэлгээ

- Археологи, палеонтологийн судалгаа хийсэн
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажил гүйцэтгэсэн

Уламжлалт газрын тос болон уламжлалт бус газрын тосны /нүүрсний давхаргын метан хийн/ хайгуулын талбайнуудад хийгдсэн ажлын товч тойм



Өнөөгийн байдлаар хайгуулын шатанд 18 БХГ, ашиглалтын шатанд 4 БХГ, 1 БХГ цуцлагдах шатанд, БХГ-т 1 талбайг буцаасан байна. Шинээр БХГ байгуулах шатанд 2, 5 БХГ шинээр байгуулсан, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д 1, гэрээлэгчгүй 17, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын нээлттэй 1 талбай байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээт хайгуулын талбайнуудад 2023-2024 онуудад хийгдсэн ажлууд:

2023 онд: Газрын тосны хайгуулын талбайд 2 цооног өрөмдөж, 547.5 км.кв 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн.

Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын талбайд хайгуул, үнэлгээ, туршилтын 41 цооног өрөмдөж, 260 т.км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн.

2024 онд: Газрын тосны хайгуулын талбайд 400 т.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 2 цооног өрөмдлөгийн ажил хийсэн.

Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын талбайд хайгуул, үнэлгээ, туршилтын 13 цооног өрөмдөж, 107.8 т.км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн байна.

2024 онд: Нийт гэрээлэгчдээс БХГ-ний төлбөр, урамшуулал **1,753,579 ам.доллар**ыг Монгол Улсын орлогод, тухайн жилийн батлагадсан төлөвлөгөө, төсвийн дагуу **22,797,011 ам.доллар**ыг газрын тосны хайгуулын ажилд зарцуулж газрын тосны хайгуулын **хөрөнгө оруулалт нийт 24,550,590 ам.доллар.**